Мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх карт мэдээ Дугаар 1

Бидний хүүхдүүд мансууруулах бодисын аюул аас ангид байна уу?

교육부
Солонгосын Боловсролын яам

한국교육환경보호원
Боловсролын орчныг хамгаалах төв

1 Мансууруулах бодис хэрэглэгчийн насны түвшин залуужиж байна

- Өнөөдөр манай улсад гарч буй мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг дотор 19-өөс доош насны өсвөр насны хүүхэд мансууруулах бодистой холбогдсон гэмт хэрэг 5 жилийн өмнөхтэй харьцуулахад 3 дахин өссөн байна.
- Мансууруулах бодисоос ангид насныхан гэж байхгүй юм.

2 Өсвөр насны мансууруулах бодис хэрэглэгч яагаад ингэж нэмэгдэж байна вэ?



- Мансууруулах бодисыг борлуулахдаа тусгайлсан газар эсвэл хүнээр дамжуулдаг байсан өмнөхөөс өөр болж интернэт, SNS-ээр хялбархан өгч авалцах хэлбэртэй болж өөрчлөгдсөн.

- Мансууруулах бодистой холбоотой өдөөсөн үг хэллэг, дүрс бичлэг нь өсвөр насныханд хүртэл ил задгай болсноор сониучирхан хүртэж үзсэн тохиолдол нэмэгдэж байна.

3 Мансууруулах бодисын улмаас учрах хохирол, гэмт хэрэгт холбогдох эрсдэл

- Өсөлтийн үедээ байгаа өсвөр насныхан мансууруулах бодист илүү мэдрэмтгий хариу үйлдэл үзүүлж, насанд хүрсэн хүнийг бодвол бие махбодийн, сэтгэлзүйн хохирол хамаагүй их байдаг. Донтолд хүрэх хурд нь ч илүү хурдан байна.

  жишээ) Ой санамж, сэтгэх чадвар муудах, түрэмгий зантай болох, худал хэлэх, хөгжлийн бэрхшээл гэх мэт

- Өсвөр нас бол үе тэнгийнхнийхээ соёлын нөлөөнд их автдаг үе учир найзууддаа ч шууд нөлөө үзүүлдэг, гэмт хэрэгт холбогдох эрсдэл ч ихэсдэг байна.

- Өсвөр насныхан мансууруулах бодисын гэмт хэрэгт холбогдох тохиолдол ч байнга нэмэгдэж байна.

4 Нягт нямбай урьдчилсан сэргийлэлт нь хамгийн шилдэг арга юм

- Мансууруулах бодисын аюулаас ангид байя гэвэл урьдчилан сэргийлэлт нь хамгийн тэргүүний зүйл юм.
- Хүүхдүүдэд мансууруулах бодисийг ил задгай байлгаж, гэмт хэргийн хохирогч болгохгүйн тулд гэр бүлийн зүгээс ч анхаарал тавьж ажиглаж байхыг хүсье.

Зөвөлгөө болон сургалтын байгууллага

Солонгосын мансууруулах бодистой тэмцэх алба: 1899-0893

•Улс даяар 13 орон нутагт хот, аймгийн салбаруудад биеэр очих, захидал, имэйл, утсаар зөвөлгөө авах боломжтой
•Эрүүл мэндийн байгууллагын эмчилгээтэй холбох

Хэвтэж эмчлүүлэх, амбултороор эмчлүүлэх болон зөвөлгөө өгөх байгууллага

Орон нутаг дахь эмчилгээ, хамгаалах байгууллага

Донтолтыг хянах цогц тусламжийн төв

Сурагчдад зориулсан мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх сургалтын материал

Сурагчдын эрүүл мэндийн мэдээллийн төв : https://schoolhealth.kr

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг мэдээллэх байгууллага

Цагдаа: 112 **Прокурор: 1301**

※Зөвөлгөө, сургалт болон эмчилгээний байгууллагаас зөвөлгөө авахад хувийн бүх мэдээллийг чанд хамгаална.
※Өөрөө төдийгүй гэр бүл, ойрын хүмүүсээрээ дамжуулан зөвөлгөө авч болно.